



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/130

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 3/03 дугаар тогтоол, аймгийн онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд “COVID-19”-ын цар тахлын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн урьдчилан сэргийлэх, халдварыг илрүүлэх түргэн оношлогооны тест болон аймгийн постуудад ажил үүрэг гүйцэтгэж буй байгууллагуудын албан хаагчдыг стандартын амны хаалтаар хангах арга хэмжээний зардлын санхүүжилтэд нийт 63256000.00 төгрөг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 63256000.00 төгрөг /жаран гурван сая хоёр зуун тавин зургаан мянган/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2021 онд 4.27-д батлагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/130 Ch

02 0909

Аймгийн Засаг даргын 2021 оны
03 дугаар сарын 15-ны өдрийн
А/130 дугаар захирамжийн хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ
ШИЛЖҮҮЛСЭН ҮЕИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЗАРДЛЫН ТООЦОО

/төгрөгөөр/

ДД	Байгууллагын нэр	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Аймгийн Эрүүл мэндийн газар	Хурдавчилсан оношлуурын тест /1ширхэг нь 5.11доллар буюу 14165 төг /	ш	4000	14564.00	58256000.00
2		Зөвлөмж, баталгааны маягт	ш	2000	1000.00	2000000.00
	Дүн					60256000.00
2	Аймгийн онцгой байдлын газар	KN 95 маск	ш	6000	500.00	3000000.00
		Нийт дүн				63256000.00

-oOo-